

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН ДАРГА,
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2014 он 04 сарын 17 өдөр

Дугаар 123/А/60

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын “Цахим засаг үндэсний хөтөлбөр батлах тухай” 2012 оны 101 дүгээр тогтоолыг үндэслэн тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Цахим систем болон мобайл технологид суурилсан програм хангамжийн нэгдсэн үйлчилгээний портал систем хөгжүүлэх” төслийн хүрээнд нийгмийн даатгалын 7 үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлэх, хэрэгжилтийг хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Ажлын хэсгийн тайланг энэ оны 6 дугаар сарын 05-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Г.Чинзориг, Г.Хүрэлбаатар/-д үүрэг болгосугай.



Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын дарга
Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2014 оны 04 сарын 17 өдрийн 126/А/60 дугаар
хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт

УХА0514 5202965

УХА0177

АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ


Зорилго:

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт орсон “Цахим засаг” үндэсний хөтөлбөрийн “Цахим систем болон мобайл технологид суурилсан програм хангамжийн нэгдсэн үйлчилгээний портал систем хөгжүүлэх” төслийн хүрээнд Нийгмийн даатгалын 7 үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлэх ажлын хэрэгжилтийг хангуулахад оршино.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа :

1. Вэб порталаар үзүүлэх нийгмийн даатгалын 7 үйлчилгээг эцэслэж баталгаажуулна.
2. Эцэслэн тогтсон 7 үйлчилгээний бизнес процессын зураглалыг баталгаажуулна.
3. Баталгаажуулсан бизнес процессын дагуу хөгжүүлэлт явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж уулзалтуудаар хөгжүүлэлтэд гарч байгаа хүндрэл, асуудлыг хамтран шийдвэрлэнэ.
4. 7 үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлэхэд шаардлагатай өгөгдлийн сангийн холболт, вэб сервис хөгжүүлэлт ба системийн нэгтгэлийг талууд хамтран ажиллаж шийдвэрлэнэ
5. Туршилтын үед гарсан алдааг талууд хэлэлцэн тохиролцсоны дагуу засварлана.
6. Үйлчилгээнүүдийг ашиглалтад өгөхдөө талуудын эрх бүхий албан тушаалтнууд баталгаажуулна.

Мэдээллийн технологи, шуудан,
харилцаа холбооны газар, Нийгмийн
даатгалын ерөнхий газрын даргын 2024
оны 02 дугаар сарын 12 ны өдрийн 25
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт /А/60



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН 7 ҮЙЛЧИЛГЭЭГ ОНЛАЙН ХЭЛБЭРТ ШИЛЖҮҮЛЭХ
ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ахлагч:

Г.Чинзориг

МТШХХГ газрын Шинэчлэлийн бодлого, төлөвлөлтийн
газрын Мэдээллийн технологи, инновацийн хэлтсийн дарга

Г.Хүрэлбаатар

Мэдээллийн технологийн төвийн захирал

Нарийн бичгийн дарга:

Ц.Пүрэвням

МТШХХГ газрын Мэдээллийн технологи, инновацийн
хэлтсийн мэргэжилтэн

Т.Цогжаргал

Мэдээллийн технологийн төвийн ахлах мэргэжилтэн

Гишүүд:

Б.Батжаргал

Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийн газрын ахлах
мэргэжилтэн

Ө.Энхбат

Мэдээллийн технологийн төвийн мэргэжилтэн

Л.Ариунтулга

Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын мэргэжилтэн

Д.Мөнхтулга

Төлөвлөлт, санхүү бүртгэлийн газрын ахлах мэргэжилтэн

А.Хишигбаяр

Эрүүл мэндийн даатгалын газрын ахлах мэргэжилтэн

